



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/688

Улаанбаатар хот

### Дүүргийн хэмжээнд архивын баримтын тооллогыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Үндэсний Архивын газар /хуучин нэрээр/-ын даргын 2003 оны 87 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн архивын ажлын үндсэн заавар”-ын 5.5, 2007 оны 59 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 4.7, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Тооллого явуулах тухай” А/688 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн албан байгууллагуудын архивын баримтыг нэгдсэн тоо бүртгэлд хамруулах, тэдгээрийн тоо хэмжээг гаргах, хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг шалгаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор архивын баримтын нэгдсэн тооллогыг 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Архивын баримтын нэгдсэн тооллогыг зохион байгуулах үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр, тооллогод хамрагдах байгууллагын жагсаалтыг 2 дугаар, тооллогын ажилд бэлтгэх төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Архивын баримтын нэгдсэн тооллого явуулах удирдлага зохион байгуулалтаар хангаж, байгууллагуудыг бүрэн хамруулж, Нийслэлийн Засаг даргын А/688 захирамжаар батлагдсан тооллогын удирдамжийн дагуу чанартай явуулж, дүн, тайланг нэгтгэн 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг салбар комиссын дарга /Б.Амартүвшин/-т үүрэг болгосугай.

4. Архивын баримтын нэгдсэн тооллого явуулах байгууллагын комиссыг томилон, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, дүн мэдээг заасан хугацаанд гаргаж салбар комиссоос хяналтын тооллого явуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг дүүргийн нийт байгууллага хэлтэс, албадын дарга, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5. Уг арга хэмжээнд шаардагдах зардлын санхүүжилтийг төлбөр хураамжийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар /Б.Амартүвшин/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ